



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1961 оны II дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 601

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын гүйцэтгэх захир-
гааны зохион байгуулалт, орон тоо,
цалингийн фондыг батлах тухай.

Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх
захиргаа аппаратад орон тоог 20 нэгч буюу 20,6%-иар, са-
ран цалингийн фондыг 11 555 төгрөг буюу 20,6%-иар хасагдуули,
зохион байгуулалтдаа өөрчлөлт оруулахаар боловсруулан ирүүл-
сэн саналыг үндэс болгон, БНМАУ Улсын Сайд нарын Зөвлөлөөс
Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс,
хөдөлмөрийн товчоо, тээврийн хэлтсийг татан буулгаж, Улаан-
баатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны
зохион байгуулалтыг дор дурдсан газар, хэлтсүүдтэй байхаар
баталсугай:

- а/хотын төлөвлөгөөний комисс;
- б/эрүүлийг хамгаалах газар;
- в/санхүүгийн хэлтэс;
- г/гэгээрлийн хэлтэс;
- д/цэргийн хэлтэс;
- е/зохион зааварлах хэлтэс;
- ж/ерөнхий хэлтэс.

2. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх
захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт орж байгаатай хол-
богдуулан, түүний дарга, орлогч дарга, хариуцлагатай нарийн
бичгийн дарга нарын ажил үүргийн хувиарыг дор дурдсанаар
баталсугай:

Хотын гүйцэтгэх захиргааны дарга/хот орны бүх ажилг
ерөнхийд нь удирдахш
хэлтэс/:

- а/барилга байгууламж, тохижуулалт, архитектурын асуудал;
- б/шүүх, цэргийн хэлтэс, цагдаа сэргийлэхийн ажил;
- в/хөдөлмөр ба бэтлэн хамгаалах нийгэмлэгийн ажил;
- г/боловсон хүчний асуудал.

← 2-р орлогч дарга:

- а/телевизорын асуудал;
- б/санхүү, төсвийн асуудал;
- в/тоо бүртгэл, хөдөлмөрийн хувиарлалтын ажил;
- г/улсын ба хоршооллын үйлдвэр;
- д/хөдөө аж ахуйн асуудал;
- е/нээлт, шинэ бүтээл, оновчтой санал.

нийгэм хамгааллын асуудал эрхэлсэн орлогч дарга:

- а/орон суудны хамгаалж ба ашиглалт;
- б/ус сувгийн ашиглалт, дулаануулах байгуулалтын ажил;
- в/халуун ус, угаалга, эвсвэр, усчин, фото зургийн үйлчилгээний газруудын ажил;
- г/тээвэр, холбооны ажил;
- д/зочид буудал.

Худалдаа, бэлтгэлийн ажил эрхэлсэн орлогч дарга:

- а/хотын худалдаа, нийтийн хоолны газруудын ажил;
- б/хоршооллын ба ном, эмийн худалдааны ажил;
- в/хөдөө аж ахуйн ба энгийн бэрээнь зах;
- г/бэлтгэлийн ажил.

Хариуцлагатай нэрлийн бичгийн дарга:

- а/засаг захиргааны байгууллагын ажил;
- б/хөдөлмөрчдийн ерөгдөл гомдол;
- в/гүйцэтгэх захиргааны аппаратын ажил;
- г/гадаад харилцааны ажил;
- д/ерөнхий боловсролын сургууль, пэцэрлэг, хүүхэд сэтгүүлэх газар, дээд ба тусгай мэрэгзлийн сургуулиудын ажил;

- е/ эмнэлэг, амралт, сувиллын газрууд;
- ж/ соёл, урлаг, биеийн тамир, спортын байгууллагын ажил;
- з/ радио, хэвлэл, номын сан, музейн ажил.

3. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны орон тоог 77 нэгчээр, сарын цалингийн фондыг 44 530 төгрөгөөр хэвсралтын ёсоор баталсугай.

4. Нийслэл хотын дотор үйлчилгээ, аж ахуйн ажлын хэмжээ өргөжин байгаатай холбогдуулан, үйлчилгээний сарин газрын зохисон байгуулалтад дор дурдсан өөрчлөлт-оруулахыг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н. БАТАА/-д зөвшөөрөх үүнд:

а/ нийгэм хангамжийн газрын харьяа үйлчилгээний газруудын удирдлагыг төвлөрүүлэн, нийгэм хангамжийн газрыг өргөтгөж, богины тээврийн базыг нийгэм хангамжийн авто базад нэгтгэх;

б/ хот тохижуулах хэлтсийг газар болгож, үйлчилгээ-аж ахуй, хот тохижуулах хэлтэстэйгээр өргөтгөн байгуулахыг тус тус зөвшөөрсүгэй.

5. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны харьяа нийгэм хангамжийн газар, хот тохижуулах газрын орон тоо, сарын цалингийн фондыг 1961 оны II дүгээр сард багтаан батлаж өхийг Улсын орон тооны комисс /н. ДУР-СҮРЭН/, Хөдөлмөр, цалин хэлсний товчоо /н. ДАВ-ЭВЭГ/ нэрт даалгасугай.

6. Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөлөөс Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны аппаратын зохисон байгуулалт, орон тоо, ажилтны цалингийн хэмжээг баталсан бүх-тогтоол, захирамж, мөн 1961 оны 94 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тоолсугай.

Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөлийн I-р орлогч дарга


Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга

МОНГОЛЫН


БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол сангийн

эрхлэгч



/ ДАГВАДОРЖ /



Сайд нарын Зөвлөлийн 1961 оны
601 дүгээр тогтоолын хавсралт.

Улаанбаатар хотын ардын депутатуудын
хурлын гүйцэтгэх захиргааны орон тоо,
сарын цалингийн фонд.

№	Албан тушаалын нэр	Орон тоо	сарын цалингийн фонд
1	Дарга	1	1500
2	1-р орлогч дарга	1	1250
3	Нийгэм хангамж эрхэлсэн орлогч дарга	1	1150
4	Худалдаа эрхэлсэн орлогч дарга	1	1150
5	Хариуцлагатай нарийн бичгийн дарга	1	1150
	ДҮН	5	6200

Хотын төлөвлөгөөний Комисс.

6	Комиссын дарга	1	1000
7	Эдийн засгийн мэрэгжилтэн	3	2100
8	Шинэ бүтээл, оновчтой санхүүгийн комиссын нарийн бичгийн дарга	1	580
9	Хөдөлмөрийн байцаагч	1	580
	ДҮН	6	4160

Эрүүлийг хамгаалах газар.

10	Газрын дарга	1	900
11	Их эмч-байцаагч	2	1450
12	Тоо бүртгэгч бөгөөд боловсон хүчний асуудал эрхэлсэн их эмч	1	700
13	Системийн нягтлан бодогч	1	600
14	Их, бага эмчийн салбар хариуцсан нягтлан бодогч	1	580
	ДҮН	6	4180

Санхүүгийн хэлтэс.

15	Хэлтсийн дарга	1	850
16	Хэлтсийн орлогч дарга	1	750
17	Бүтэцийн нягтлан бодогч	1	700

18: Санхүү-эдийн засгийн мэрэгжилтэн	1	700
19: Тайлан балансын мэрэгжилтэн	1	700
20: Орлого эрхэлсэн байцаагч	2	1060
21: Албан тэтгэвэрн байцаагч ✓	4	2120
22: Даатгалын байцаагч	1	530
23: Хяналт, шалгалтын байцаагч	4	2120
24: Эхчүүдийн тэтгэвэр эрхэлсэн байцаагч	2	1060
ДҮН	18	10590

Гэгээрлийн хэлтэс.

25: Хэлтсийн дарга	1	825
26: Заах аргын мэрэгжилтэн	1	700
27: Сургуулийн байцаагч /дээд боловсролтой/	1	600
28: Цэцэрлэг хариуцсан байцаагч /дээд боловсролтой/	1	600
29: Системийн нягтлан бодогч	1	600
30: Бага сургууль хариуцсан нягтлан бодогч	1	530
ДҮН	6	3855

Цэргийн хэлтэс.

31: Хэлтсийн дарга	1	800
32: Хэлтсийн туслах	2	1400
ДҮН	3	2200

Зохион зааварлах хэлтэс.

33: Хэлтсийн дарга	1	825
34: Зааварлагч	2	1060
35: Боловсон хүчин эрхлэгч	1	650
36: Боловсон хүчин, гадаад харилцааны асуудал эрхэлсэн ✓ зааварлагч	1	530
37: Соёл, урлаг хариуцсан зааварлагч	1	530
38: Архивын эрхлэгч	1	520
39: Фондоч	1	420
ДҮН	8	4545

Брөнхий хэлтэс.

40: Хэлтсийн дарга	1	700
--------------------	---	-----

		3.
41: Нягтлан бодогч	1	600
42: Командант	1	450
43: Бичиг хэргийн эрхлэгч	1	450
44: Бичээч	3	1020
45: Бичиг хүргэгч	1	230
46: Суудлын машины жолооч	1	500
47: Ачааны машины жолооч	2	800
48: Уурын зуухны механик	1	550
49: Уурын зуухны галч	3	900
50: Ердийн пийшингийн галч	1	230
51: Конторын цэвэрлэгч	4	920
52: Дежур	3	720
53: Хар ажилчин	1	230
54: Даргын нарийн бичгийн дарга	1	500
	<u>ДҮН 25</u>	<u>8800</u>
	БҮГД 77	44530